

НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН СУУРЬ-ОЧИРЫН ДОЛГОРСҮРЭНГИЙН
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт -ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Боловсролын салбарын хууль тогтоомж, бодлого стратеги, тогтоол шийдвэр, үндэсний болон орон нутгийн дэд хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлэх, зохицуулах, үр дүнг үнэлж тайлагнана.							
1.	Арга хэмжээ 1.1. Боловсролын салбарын бодлогын баримт бичгийн орон нутагт хамааралтай зорилт, заалтын хэрэгжилтийн мэдээ тайланг хугацаанд нь гаргаж тайлагнана.	Тайлан мэдээний тоогоор болон хугацаандаа тайлагнасан эсэх	12	12	- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамааралтай заалтын биелэлт, - Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамааралтай заалтын биелэлт, - Улсын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамааралтай заалтын биелэлт, - Ерөнхийлөгчийн 1 зарлиг, Засгийн газрын 8 тогтоол, Сайдын 3 тушаал, ИТХ-ын 1 тогтоол, Засаг даргын 3 захирамж, нийт 12 шийдвэрийн биелэлт, - Боловсролын сайд болон аймгийн Засаг даргын хооронд орон нутагт боловсролын салбарт хамтран ажиллах гэрээний хэрэгжилт,	2025.01 сараас 2025.06 сар	100

					- Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамааралтай заалтын биелэлт, - Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамааралтай заалтын биелэлт, - Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрт туссан боловсролын салбарт хамааралтай заалтын биелэлт, - Өвөрхангай аймгийн Хүний эрхийн 2024 оны тайланд 6 тайлан, - Засаг даргын Тамгын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэлтэст хамааралтай заалтын хагас жилийн биелэлт, - Хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлт - Агентлагийн сарын ажлын жагсаалт нийт 12 тайланг гарган, холбогдох хэлтэст хүргүүлсэн.		
Зорилт 2. Аймгийн боловсролын салбарын хөгжлийн стратегийг төлөвлөх, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангах, хяналт, шинжилгээ хийх							
2.	Арга хэмжээ 2.1. Аймгийн боловсролын салбарын хөгжлийн төлөвлөх стратегийг	Боловсруулсан баримт бичгийн тоогоор	4	4	- Боловсролын сайд болон аймгийн Засаг даргын 2025 онд хамтран ажиллах гэрээнд тусгах саналын төслийг боловсруулан, баталгаажуулж, албан бичгээр 2 удаа хүргүүлсэн. - Аймгийн жилийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд боловсрол, шинжлэх ухааны салбараас тусгах санал, - Засаг даргын Тамгын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд боловсролын салбараас тусгах санал,	2025.01 сараас 2025.06 сар	100

					- Хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд боловсролын салбараас тусгах санал зэргийг боловсруулж ажилласан.		
3.	Дэд арга хэмжээ 2.2. Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих, багшийн дутагдлыг арилгах, нийгмийн асуудалд үе шаттай дэмжлэг үзүүлэх зорилгоор “Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар	-	30.0	“Багшийн хөгжил” аймгийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан, 2 удаа хуралдаж, гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган, эзэнжүүлж өгсөн. Төлөвлөлтийн дагуу судалгааны ажлуудыг хийж, 4 удаагийн хэлэлцүүлгийг багш нар, удирдах ажилтнуудын дунд зохион байгуулан, хөтөлбөрийн тангилцуулга бэлтгэж, 4 шатны хурлаар төслийг хэлэлцүүлснээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 03/03 тогтоолоор батлагдсан. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг Боловсролын газартай хамтран боловсруулж, Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын ... өдрийн А/.. дугаар захирамжаар батлан, хэрэгжүүлж байна.	2025.01 сараас 2025.06 сар	100
Зорилт 3. Насан туршийн суралцахуйн чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн дэмжлэгээр хангаж, сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.							
4.	Арга хэмжээ 3.1. Хүүхэд, залуучуудад чиглэсэн хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох чиг үүрэг бүхий “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл”-ийн журмыг боловсруулан, хэрэгжүүлэх	Батлагдсан баримт бичгийн тоогоор	-	1	“Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл”-ийн журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудын дунд хэлэлцүүлэн, гарсан санал, дүгнэлтийг тусган, боловсруулж, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/320 дугаар захирамжаар батлагдсан баримт бичгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын	2025.04 сараас 2025.05 сар	100

					Нийгмийн бодлогын хэлтсийн даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 3-6/298 дугаар албан бичгээр орон нутагт хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.		
Зорилт 4. Аймгийн Засаг даргын дэргэдэх орон нутгийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах							
5.	Арга хэмжээ 3.1. Аймгийн Засаг даргын дэргэд ажиллах албан тушаалын чиг үүргийн дагуу хариуцсан салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, биелэлт үр дүнг тайлагнана.	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувиар	60.0	60.0	- Хэлний бодлогын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2025 оны дугаар сарын 05-ны өдрийн А/ дүгээр захирамжаар шинэчлэн байгуулж, хурлыг 2 удаа зохион байгуулан, төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний дагуу сумын Засаг дарга нарт цахим сургалт зохион байгуулж, чиглэл, арга зүйгээр хангасан ба “Хос бичигтэн” аяныг зарлаад байна. Мөн төрийн албан хаагчдаас үндэсний бичгийн сорил авахад аймгийн 35 байгууллага, 19 сумдын нийт 1394 төрийн албан хаагч хамрагдаж нийт 69700 оноо авахаас 30116 оноо авч 43,2 хувийн гүйцэтгэлтэй шалгагдсан байна. “Бичиг үсгийн баяр” уламжлалт арга хэмжээнд оролцож, хамтран зохион байгуулав. - Шинжлэх ухаан технологи, инновацын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд орох эрдэмтдийг судлах зорилгоор орон нутгаас төрөн гарсан нийт эрдэмтдийн судалгааг гаргав. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах захирамжийн төслийг бэлэн болгосон ба нутгийн зөвлөлийн уулзалттай холбогдуулан түр хойшлуулаад байна. Шинжлэх ухаан технологи, инновацын үндэсний зөвлөлд аймгийн салбар	2025.01 сараас 2025.06 сар	50.0

					зөвлөлийн нарийн бичгийн талаар мэдээлэл хүргүүлсэн болно.		
--	--	--	--	--	--	--	--

НЭМЭЛТ ҮҮРЭГ, ДААЛГАВАР, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг, даалгавар, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
6.	Аймгийн Засаг даргын шийдвэрийн төслийг боловсруулан, эцэслэж гаргах	Шийдвэрийн тоогоор	20	-	Нийт 34 шийдвэрийн төсөл боловсруулан гаргасан байна.	2025.01 сараас 2025.06 сар	100
7.	Салбарын холбогдох асуудлаар албан бичиг боловсруулж, хүргүүлэх	Албан бичгийн тоогоор	4	-	Салбарын холбогдох асуудлаар 12 албан бичиг, 2 өргөдлийн хариуг боловсруулж, холбогдох байгууллага, албанд хүргүүлэв.	2025.01 сараас 2025.06 сар	100
8.	Ажлын хэсэгт ажиллах	Хамрагдсан байгууллагын тоогоор	2	2	“Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсэгт ажиллаж, Төрийн албаны зөвлөлөөс ахлах ангийн сурагчдад хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг ханган, хамтран ажиллав.	2025.02 сард	100
9.	“Дүүдү шинжлэх ухааны музей”, Монголын STEAM боловсролын академаас зохион байгуулсан сургалтын бэлтгэл ажлыг орон нутагт хангах, хамтран зохион байгуулах	Ажлын гүйцэтгэлээр	-	-	- Teamwork&Teamplay багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, хамт олныг идэвхижүүлэн, уур амьсгалыг нэгтгэх “үйлдэн суралцах” олон улсын сургалтад 50 төрийн албан хаагчийг хамруулсан бол - “Орчин үеийн боловсролын чиг хандлага ба steam ” сургалтад Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 150 багшийг хамруулан зохион байгуулж,	2025.02 сард	100

					шийдвэрийн төсөл, сургалтын байр, үдийн цай, хоол, ирцийн бүртгэл, илтгэх хуудас зэргийг хариуцан ажилласан болно.		
10.	Удирдлагыг салбарын мэдээллээр хангах	Мэдээллийн тоогоор	3	2	- Төрийн албан хаагчдаас TOFEL шалгалтын дүйцүүлсэн сорилоор шалгалт авах ажлыг зохион байгуулав. - Байгууллагын хэвлэлийн мэргэжилтэнд зохион байгуулсан арга хэмжээний талаар 2 удаагийн мэдээ бэлтгэж өгөв. - Аймгийн Засаг даргын Улсын Физикийн олимпиадын нээлтийн арга хэмжээний нээлтийн үгийг боловсруулав. - Архангай аймагт зохион байгуулагдсан Бүсчилсэн хөгжлийн зөвлөгөөний үеэр танилцуулах салбарын мэдээллийг холбогдох хэлтэст боловсруулж, өгөв. - Хэлсний бодлогын сумын зөвлөлийн гишүүдийг удирдлага, арга зүйгээр хангах, чиглэл өгөх цахим сургалтын хэлтсийн даргын илтгэлийг бэлдэв. - ESEL хөтөлбөрийг хэрэгжүүлэх журмыг сумын Засаг дарга нарт танилцуулах цахим уулзалт, хэлэлцүүлгийн үеэр тавих хэлтсийн даргын танилцуулгыг бэлтгэв. - Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд сургуулийн багш нарт хэлэлцүүлэг зохион байгуулж, 6-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль болох шийдвэрийн төслийн талаар саналыг авсан.	2025.01 сараас	100

ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин(биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Монгол бичгээр компьютерийн хэрэглээний программд бичиж сурна.	Албан бичгийн тоогоор	4	5	Монгол бичгээр компьютерийн хэрэглээний программд бичиж сурч байна. Нийт 5 албан бичгийг үндэсний бичгээр бичиж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.	2025.01 сараас 2025.06 сар	100.0
2.	Төрийн албан хаагчдад зориулсан сургалт семинарт хамрагдана.	Хамрагдсан сургалтын тоогоор	2	2	- Teamwork&Teamplay багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, хамт олныг идэвхижүүлэн, уур амьсгалыг нэгтгэх “үйлдэн суралцах” олон улсын сургалтад 1 өдөр - “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” бүсийн зөвлөгөөний үеэр төрийн албан хаагчдад зохион байгуулсан сургалтад 1 өдөр тус тус хамрагдав.	2025.2 сараас 2025.05 сар	100.0

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боловсролын салбарын бодлого,
зохицуулалтын асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

 (С.Долгорсүрэн)

2025-06-09.